



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/65

Бөхт

Шууд гэрээ байгуулах эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 124 дүгээр тогтоол, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 87 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны хөрөнгө оруулалтаар хийгдэх “Малчдад зориулсан сургалт, сурталчилгаа зохион байгуулах ажил”-ыг 10,000,000 (арван сая) төгрөгөөр “Шилийн ирээдүй” НҮТББ-тай шууд гэрээ байгуулсугай.

2. “Малчдад зориулсан сургалт, сурталчилгаа зохион байгуулах ажил”-ыг удирдамжийн дагуу үр дүнтэйгээр зохион байгуулахыг “Шилийн ирээдүй” НҮТББ-ын Төлөөлөн удирдан зөвлөлийн дарга (Ж.Адъяа)-д даалгасугай.

3. “Шилийн ирээдүй” НҮТББ-тай шууд гэрээ байгуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Амгаланжаргал)-д, ажлын уялдааг хангаж, гүйцэтгэлийн хяналт тавьж ажиллахыг Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн (Х.Уугандорж) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



У.АЛТАНХҮҮ